

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ


Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2022/23/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.audit.mn
Арвайхээр
2022 он

Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: О.Батжаргал
Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Гансүх
Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com
Аудитор: Б.Авидцэрэн
Утас: 70323833 Цахим хаяг: AvidtserenB@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Аудитын тайлан
- 3.1 Ерөнхий зүйл
- 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Материаллаг байдал
- 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....
- 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....
- 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг
- 3.8 Аудитын гол асуудал.....
- 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
4. Аудитын илрүүлэлт.....
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. Аудитын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гандонгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173
Утас/Факс: (976) 7052 3252
Цахим шувдан: ovorkhanga@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

БАРУУНБАЯН-УЛААН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Д БАЙГАЛЬМАА ТАНАА

дэдд 02 25 № 243
Танай _____ -ны № _____ -и

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ес зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэггүй гэдгийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	32,831,906.54	141,663,296.93
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	853,120.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	853,120.00
31210	Төгрөг	-	853,120.00
31211	Төрийн сангийн харилцах	-	853,120.00
33	АВЛАГА	2,503,840.00	48,223,027.08
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,503,840.00	1,251,627.08
33102	НДШ-ийн авлага	-	1,251,627.08
33105	ЭМДС-аас авах авлага	2,503,840.00	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	46,971,400.00
35	БАРАА МАТЕРИАЛ	30,328,066.54	92,587,149.85
35100	Түүхий эд материал	16,336,626.54	64,655,902.85
35110	Тусгай зориулалттай материал	4,520,079.50	6,518,369.73
35130	Эм боох материал	11,816,547.04	58,137,533.12
35400	Хангамжийн материал	13,991,440.00	27,931,247.00
35410	Бичиг хэргийн материал	82,900.00	320,951.00
35420	Аж ахуйн материал	12,394,800.00	19,894,510.00
35450	Барилгын засварын материал	562,000.00	562,000.00
35460	Хүнсний материал	629,740.00	5,349,586.00
35470	Бусад хангамжийн материал	322,000.00	1,804,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	445,845,486.28	418,218,799.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	445,845,486.28	418,218,799.78
39200	Биет хөрөнгө	436,401,486.28	408,774,799.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	205,182,617.92	205,182,617.92
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(12,096,973.85)	(18,046,925.69)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	48,836,434.00	91,836,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(21,500,105.78)	(30,122,844.90)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	530,888,947.34	565,603,955.34
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(326,656,562.14)	(416,272,217.54)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,559,545.06	13,499,545.06
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(10,728,418.86)	(11,518,546.60)
39209	Зам, гүүрийн байгууламж	4,186,777.00	4,186,777.00
39210	Хуримтлагдсан элэгдэл - Зам гүүр	(668,440.68)	(1,081,661.04)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,800,000.00	17,800,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн	(11,495,833.73)	(12,385,833.77)
39217	Номын фонд	93,500.00	93,500.00
39300	Биет бус хөрөнгө	9,444,000.00	9,444,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9,444,000.00	9,444,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	478,677,392.82	559,882,096.71
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	2,503,840.00	46,971,400.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,503,840.00	46,971,400.00
41300	Өглөг	2,503,840.00	46,971,400.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	21,520,350.00
41311	Цалингийн өглөг	-	19,129,200.00
41312	НДШ-ийн өглөг	-	2,391,150.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,503,840.00	25,451,050.00
413205	Тээвэр, шатахууны өглөг	-	400,000.00
413208	Хоолны өглөг	-	300,000.00
413209	Эмийн өглөг	2,503,840.00	24,751,050.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	476,173,552.82	512,910,696.71
51	Засгийн газрын хувь оролцоо	476,173,552.82	512,910,696.71
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	308,980,043.00	308,980,043.00
51200	Хуримтлагдсан үр дүн	90,507,833.40	127,244,977.29
51210	Өмнөх үеийн үр дүн	90,507,833.40	90,507,833.40
51220	Тайлант үеийн үр дүн	-	36,737,143.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	76,685,676.42	76,685,676.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	478,677,392.82	559,882,096.71

Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	420,637,590.00	855,843,233.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	379,165,090.00	610,825,573.15
1200	Нийтлэг татварын бус орлого	31,998,390.00	235,748,273.15
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	19,020,000.00	73,035,008.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,099,100.00	162,713,265.15
1230	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	347,166,700.00	375,077,300.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	324,736,500.00	349,220,400.00
123003	дэмжлэг	22,430,200.00	25,856,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	41,472,500.00	245,017,660.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	129,990,200.00	213,317,400.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		457,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	-	26,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	186,260,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	31,700,260.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	28,473,300.00	31,700,260.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	499,905,142.21	819,106,089.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	499,905,142.21	819,106,089.26
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	499,905,142.21	792,506,089.26
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	256,536,721.71	333,622,672.92
210101	Үндсэн цалин	166,703,721.71	168,294,472.92
210102	Нэмэгдэл	67,574,000.00	67,574,000.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	5,544,000.00	5,670,000.00
210104	Урамшуулал	16,715,000.00	92,084,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,498,300.00	44,554,700.00
210201	Тэтгэврийн даатгал	21,418,800.00	34,055,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,519,900.00	2,624,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,015,900.00	2,099,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	504,000.00	524,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,039,700.00	5,249,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,433,200.00	24,356,900.00
210301	Гэрэл, цахилгаан	3,517,100.00	3,438,000.00
210302	Түлш, халаалт	17,833,100.00	19,538,900.00
210303	Цэвэр, бохир ус	1,080,000.00	1,380,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,642,921.80	35,952,939.00
210401	Бичиг хэрэг	689,100.00	1,861,949.00
210402	Тээвэр, шатахуун	28,237,200.00	23,067,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,130,000.00	2,130,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	332,480.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,775,960.00	8,561,110.00
2105	Нормативт зардал	28,301,204.00	237,754,582.84
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,345,694.00	227,329,428.84
210502	Хоол, хүнс	5,955,510.00	8,580,154.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,845,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,196,000.00	4,301,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	70,000.00	80,000.00
210604	Урсгал засвар	1,126,000.00	4,221,400.00

Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	1,325,000.00	1,145,000.00
210702	Дотоод албан томилолт	1,325,000.00	1,145,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	695,200.00	691,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	594,700.00	590,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,900.00	49,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	8,000.00	8,000.00
210807	Газрын төлбөр	43,600.00	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,276,594.70	110,126,894.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,240,200.00	3,845,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	114,036,394.70	106,281,694.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	26,600,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	26,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	26,600,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	79,267,552.21	36,737,143.89
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	79,267,552.21	36,737,143.89

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	308,980,043.00	76,685,676.42	90,507,833.40	476,173,552.82
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	308,980,043.00	76,685,676.42	90,507,833.40	476,173,552.82
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
8	Тайлант үеийн үр дүн	-	-	36,737,143.89	36,737,143.89
9	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	308,980,043.00	76,685,676.42	127,244,977.29	512,910,696.71

Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	388,639,200.00	573,123,560.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	347,166,700.00	375,077,300.00
1230	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	347,166,700.00	375,077,300.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	324,736,500.00	349,220,400.00
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	22,430,200.00	25,856,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	41,472,500.00	198,046,260.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,999,200.00	166,346,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	457,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	12,999,200.00	26,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	139,288,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	28,473,300.00	31,700,260.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	28,473,300.00	31,700,260.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	388,639,200.00	566,650,440.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	388,639,200.00	566,650,440.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	386,135,360.00	540,050,440.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	256,486,000.00	315,745,100.00
210101	Үндсэн цалин	166,653,000.00	169,546,100.00
210102	Нэмэгдэл	67,574,000.00	67,574,000.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	5,544,000.00	5,670,000.00
210104	Урамшуулал	16,715,000.00	72,955,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,498,300.00	42,163,550.00
210201	Тэтгэврийн даатгал	21,418,800.00	31,664,750.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,519,900.00	2,624,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,015,900.00	2,099,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	504,000.00	524,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,039,700.00	5,249,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,430,200.00	24,356,900.00
210301	Гэрэл, цахилгаан	3,517,100.00	3,438,000.00
210302	Түлш, халаалт	17,833,100.00	19,538,900.00
210303	Цэвэр, бохир ус	1,080,000.00	1,380,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,922,200.00	41,044,500.00
210401	Бичиг хэрэг	750,000.00	2,100,000.00
210402	Тээвэр, шатахуун	27,237,200.00	22,667,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,130,000.00	2,130,000.00
210405	ариутгал	500,000.00	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,305,000.00	13,647,100.00
2105	Нормативт зардал	31,214,260.00	105,684,390.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,317,160.00	88,184,390.00
210502	Хоол, хүнс	5,897,100.00	13,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	4,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	4,420,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00	2,420,000.00
210604	Урсгал засвар	-	2,000,000.00

Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	1,325,000.00	1,145,000.00
210702	Дотоод албан томилолт	1,325,000.00	1,145,000.00
2108	хураамж	695,200.00	691,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	594,700.00	590,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,900.00	49,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	8,000.00	8,000.00
210807	Газрын төлбөр	43,600.00	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,594,200.00	4,800,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,594,200.00	4,800,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,503,840.00	26,600,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	26,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	26,600,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	-	6,473,120.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	5,620,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	5,620,000.00
223	БУСАД ХӨРӨНГӨ	-	5,620,000.00
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	5,620,000.00
6	V)	-	(5,620,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-	853,120.00
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	853,120.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	165,124,840.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	165,124,840.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	138,524,840.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	56,273,100.00
210101	Үндсэн цалин	-	8,393,100.00
210104	Урамшуулал	-	47,880,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	7,134,950.00
210201	Тэтгэврийн даатгал	-	7,134,950.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	3,767,400.00
210401	Бичиг хэрэг	-	500,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	667,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,600,000.00
2105	Нормативт зардал	-	70,559,390.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	65,559,390.00
210502	Хоол, хүнс	-	5,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	500,000.00
210604	Урсгал засвар	-	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	290,000.00
210702	Дотоод албан томилолт	-	290,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	26,600,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	26,600,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	26,600,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	165,124,840.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	165,124,840.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан	-	2,961,240.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	-	29,103,840.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	138,067,440.00
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-
12	Татварын бус орлого	404,273,720.00	404,273,720.00
122	Тусламж, санхүүжилтийн орлого	55,053,320.00	55,053,320.00
122001	Хандив тусламж /Дотоод/	29,196,420.00	29,196,420.00
122005	Төсвөөс санхүүжих	25,856,900.00	25,856,900.00
123	Татаас санхүүжилтийн орлого	349,220,400.00	349,220,400.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	349,220,400.00	349,220,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	403,420,600.00	407,145,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	403,420,600.00	407,145,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	403,420,600.00	407,145,600.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	259,472,000.00	259,472,000.00
210101	Үндсэн цалин	161,153,000.00	161,153,000.00
210102	Нэмэгдэл	67,574,000.00	67,574,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,670,000.00	5,670,000.00
210104	Урамшуулал	25,075,000.00	25,075,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,028,600.00	35,028,600.00
210201	Тэтгэврийн даатгал	24,529,800.00	24,529,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,624,700.00	2,624,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,099,800.00	2,099,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	524,900.00	524,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,249,400.00	5,249,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,356,900.00	24,356,900.00
210301	Гэрэл, цахилгаан	3,438,000.00	3,438,000.00
210302	Түлш, халаалт	19,538,900.00	19,538,900.00
210303	Цэвэр, бохир ус	1,380,000.00	1,380,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	40,517,100.00	40,517,100.00
210401	Бичиг хэрэг	1,600,000.00	1,600,000.00
210402	Тээвэр, шатахуун	22,000,000.00	22,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,130,000.00	2,130,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,287,100.00	14,287,100.00
2105	Нормативт зардал	31,400,000.00	35,125,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,900,000.00	22,625,000.00
210502	Хоол, хүнс	8,000,000.00	8,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,500,000.00	4,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,300,000.00	6,300,000.00
210601	Багаж, техник хэрэгсэл	4,800,000.00	4,800,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	Томиллолт, зочны зардал	855,000.00	855,000.00
210702	Дотоод албан томиллолт	855,000.00	855,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	691,000.00	691,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	590,000.00	590,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,000.00	49,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	8,000.00	8,000.00
210807	Газрын төлбөр	44,000.00	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,800,000.00	4,800,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,800,000.00	4,800,000.00
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	3,725,000.00
38	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,725,000.00
381105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,725,000.00
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	853,120.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд 3 зөвлөмж өгсөн болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Авидцэрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Аймгийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төв нь үйлчлэх хүрээний хүн амд тэгш хүртээмжтэй, чанартай эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэн, хүн амын эрүүл мэндийн байдлыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд тус байгууллагын санхүүжилтийн тогтолцоонд өөрчлөлт орж, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих болсон ба байгууллагын бусад үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа эрүүл мэндийн салбарын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон боловч 2011 онд батлагдсан тул зарим өөрчлөлтийг хийж шинэчлэх шаардлагатай болсон байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д нийцүүлэн гаргасан "Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам"-ыг ерөнхий эмчийн тушаалын хавсралтаар баталсан, 2021 оны ажлын төлөвлөгөө гаргаж ажилласан байна.

Байгууллагын зохион байгуулалтын бүтцэд дотоод аудитын нэгж байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1.0 хувиар буюу 5.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувь буюу 3.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө, бараа материалын болон авлага, өглөгийн тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгө оны эхнээс 78.6 сая төгрөгөөр өссөн байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтаар 73.0 сая төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж хүлээн авсан, 5.6 сая төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэнтэй холбоотой байна.
- Бараа материалын үлдэгдэл оны эхнээс 62.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь эм, тусгай зориулалтын материал хөрөнгө оруулалтаар огцом өссөнөөс шалтгаалжээ.
- Эрүүл мэндийн даатгалын сангаас ковид-19 халдварын эмчилгээний зардлын санхүүжилтээс 47.0 сая төгрөг олгоогүй он дамжуулснаар энэ хэмжээний авлага үүсгэсэн байна.
- Дээрх авлагаас ажиллагсдад олговол зохих урамшуулал, бараа үйлчилгээний зардлын өглөг, эмийн өглөг, нийт 47.0 сая төгрөгийн өглөг тайлагнажээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, аймгийн Эрүүл мэндийн газарт нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 352.2 сая төгрөгөөр төлөвлөсөн ба санхүүжилт 349.2 сая төгрөгөөр батлагджээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайланд оны төсөв 349.2 сая төгрөгөөр батлагдаж, санхүүжилт бүрэн ирсэн байна. Оны нийт төсвийн гүйцэтгэл 407.1 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилт тайлант онд 166.3 сая төгрөг, тухайлбал:

- Ковид-19 халдварын эмчилгээний зардалд эрүүл мэндийн даатгалын сангаас 135.6 сая,
- Монголын сумын эмч мэргэжилтний холбооноос 0.4 сая,
- Дээд шатны байгууллага болох аймгийн Эрүүл мэндийн газраас 26.6 сая,
- байгууллагын өөрийн орлого 3.7 сая төгрөг тус тус орж, зориулалтын дагуу зарцуулагджээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Аудит хийх цаг хугацааны боломж болон эрсдэлийн байдлаас шалтгаалан тухайн байгууллагын тайлант оны цалингийн тооцоололд аудитын горим, сорил хэрэгжүүлээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв:

- Байгууллагын өөрийн орлогын 3.7 сая төгрөг, түүний зарцуулалтыг санхүүгийн тайлан, бүртгэлд тусгаагүй байсанд залруулга хийсэн.
- Шинжилгээний төлбөрийн орлогыг байгууллагын төрийн сан дахь нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлээгүй.
- Урсгал зардлын төсвөөс 2.4 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн.
- Ашиглах хугацаа дууссан үндсэн хөрөнгөнд үнэлгээ хийж, шинээр үнэ, хугацаа тогтоолгох хэрэгтэй болсон байна.
- Эм, эмнэлгийн хэрэгслийн орлого, зарлагыг бараа материалын тайлан, тооллогын бүртгэлд нэр төрлөөр тусгасан боловч санхүүгийн бүртгэлд бөөн дүнгээр бүртгэсэн тул тэдгээр хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төв нь шилэн дансны цахим хуудсанд нийт 150 мэдээлэл байршуулахаас 144 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулаагүй ба санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг байршуулах хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой

байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй, 2 албан шаардлага өгснийг хэрэгжүүлж, биелэлтийг албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2021 онд цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан эрүүл мэндийн байгууллагуудын цалин, урамшуулалтай холбоотой гарсан тогтоол, шийдвэрийн зарим нь дараагийн онд үргэлжлэн хэрэгжих тул эдгээрийн хэрэгжилтэд анхаарал хандуулах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2.4 сая төгрөгийн зөрчил, 7.4 сая төгрөгийн алдаа илэрсэн.

4.1 Залруулсан алдаа

Шинжилгээний төлбөрийн 3.7 сая төгрөгийн орлого, түүний зарцуулалтыг санхүүгийн тайлан, бүртгэлд тусгаагүй байсан алдааг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Акт тавигдаагүй.

4.3 Албан шаардлага

Урсгал зардлын төсвөөс үндсэн хөрөнгө бэлтгэхийг таслан зогсоож, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д: "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг мөрдөж ажиллахыг шаардсан.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого төвлөрүүлэлтийн асуудал

1.1. Илрүүлэлт:

Шинжилгээний төлбөрийн орлогыг байгууллагын төрийн сан дахь нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлээгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шинжилгээний төлбөрийн орлогыг байгууллагын төрийн сан дахь нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн, Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь заалт, Монгол улсын шадар сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 05/A/12 тоот тушаалыг мөрдөж ажиллах.

2. Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааны асуудал

2.1. Илрүүлэлт:

Ашиглах хугацаа дууссан үндсэн хөрөнгөнд үнэлгээ хийж, шинээр үнэ, хугацаа тогтоолгох хэрэгтэй болсон байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Ашиглах хугацаа дууссан үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийж, шинээр үнэ, хугацаа тогтоолгох ажлыг хууль, журамд нийцүүлэн зохион байгуулах.

3. Бараа материалд бүртгэлээр тавих хяналтын асуудал

3.1. Илрүүлэлт:

Эм, эмнэлгийн хэрэгслийн орлого, зарлагыг бараа материалын тайлан, тооллогын бүртгэлд нэр төрлөөр тусгасан боловч санхүүгийн бүртгэлд бөөн дүнгээр бүртгэсэн тул тэдгээр хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Бараа материалын орлого, зарлагыг санхүүгийн бүртгэлд нэр төрлөөр тусгаж, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төв	5	9.8	1	3.7			1	2.4	3	3.7

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

Б.АВИДЦЭРЭН

